| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 73,113,100.00 | 73,112,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,072,600.00 | 2,072,600.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,186,907,400.00 | 2,777,896,488.50 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,634,113,900.00 | 2,248,103,551.22 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,634,113,900.00 | 2,248,103,551.22 |
| | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 552,793,500.00 | 529,792,937.28 |
| | Орон нутгийн төсвөөс | 552,793,500.00 | 529,792,937.28 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 83.00 | 83.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 52.00 | 52.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 30.00 | 30.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | / төгрөгөөр / Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|--|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 36,974,790.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 36,974,790.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 26,532,895.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,469,505.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,431,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,290,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,382,155.00 |

| | | |
|-------------|--|----------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,365,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 142,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 124,500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,010,990.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,010,990.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,112,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,112,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,798,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,320,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 478,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,441,895.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 800,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,641,895.40 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 9,641,895.40 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 36,974,790.40 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 36,974,790.40 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 36,974,790.40 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн эрхэм зорилго нь "Дэвшилтэт технологи инновацыг хөгжүүлэгч сургууль болох" юм. 2023 онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

- Байгууллагын соёл, ёс зүйг төлөвшүүлэх
- Оюутан суралцагчийн хөгжил, олон нийтийн ажилд сайн дураар оролцох, зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлэх
- Хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, төгсөгчийн мэдлэг ур чадварыг олон улсын түвшинд дүйцүүлэн үнэлэх, тооцох баталгаажуулах
- Сургалтын шаталсан тогтолцоог бий болгох, сургууль хоорондын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, суралцагчдын ур чадварын зөрүүг арилгаж сургалтын чанарыг дээшлүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индексийг нэвтрүүлэх
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэх, гомдол саналыг цахимаар хүлээн авч шийдэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэгдэн батлагдсан
- Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2023 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив батлах тухай"
- Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллеж нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа ба зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 262,244.0 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|--------------------|--------------------|-------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 12,809.4 | 10,526.3 | -2,283.1 |
| Авлага | 19,189.0 | 12,780.1 | -6,408.9 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 335,760.1 | 282,857.5 | -52,902.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,052,840.3 | 3,852,191.1 | -200,649.2 |
| Нийт хөрөнгө | 4,420,598.9 | 4,158,354.9 | -262,244.0 |
| Өр төлбөр | 22.0 | 0.0 | -22.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,420,576.9 | 4,158,354.9 | -262,222.0 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 4,420,598.9 | 4,158,354.9 | -262,244.0 |

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,283.1 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын санг зарцуулснаас шалтгаалжээ.
- Бараа материалын дансны үлдэгдэл 282,857.5 мянган төгрөг болж 52,902.6 мянган төгрөгөөр буурсан нь 67,502.6 мянган төгрөгийн бараа материал акталснаас шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,852,191.1 мянган төгрөг болж 200,649.2 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлээс шалтгаалжээ. Тухайлбал, үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 15,341.5 мянга, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 17,603.0 мянга, аймгийн ОНХС-гаар 2,500.0 мянга, өмнөх онд үүсгэсэн авлага 3,677.0 мянга, бусад 672.0 мянга нийт 39,793.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,158,354.9 мянган төгрөг болж 262,244.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,285,287.9 мянга, нийт зарлагыг 2,285,287.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 634,725.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,650,562.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 983,551.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,634,113.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 552,793.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,634,113.9 мянга, орон нутгийн төсвөөс 552,793.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,777,896.5 мянган төгрөг буюу 87.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 258,842.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 5,097.0 мянга, хангамж, бараа материалын зардлыг 7,053.2 мянга, нормативт зардлыг 80,486.7 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 16,042.2 мянга, томилолт, зочны зардлыг 1,565.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйчилгээний төлбөр зардлыг 1,893.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 15,029.4 мянга, бусад урсгал шилжүүлэг зардлыг 0.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,000.6 мянга нийт 409,010.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|-----------------------|--------------------|--------------------|------------------|-------------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | 71804-80101 | 2,358,575.2 | 2,042,769.8 | 315,805.4 | 86.6 |
| 2 | 71804-80802 | 95,669.5 | 95,669.1 | 0.4 | 99.9 |
| 3 | 71804-81806 | 179,869.2 | 109,664.7 | 70,204.5 | 60.9 |
| 4 | 71804-80112 | 552,793.5 | 529,792.9 | 23,000.6 | 95.8 |
| | Нийт | 3,186,907.4 | 2,777,896.5 | 409,010.9 | 87.2 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд заалны орлого 5,760.0 мянга, байрны түрээсийн орлого 26,032.0 мянга, программ буцаалтын орлого 2,770.0 мянга, Байгаль орчны мэдээлэл сургалтын төвөөс урамшуулал 800.0 мянга, цахим тендерийн орлого 105.0 мянга, аймгийн ОНХС-гаас 360.0 мянга, урьд оны авлага барагдуулалт 280.6 мянга, бусад орлого 867.2 мянга, нийт 36,974.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Шатахууны зардалд 4,290.0 мянга, томилолтын зардалд 3,036.0 мянга, гал тогооны тоног төхөөрөмжийн зардалд 6,000.0 мянга, хүүхдийн баярын бэлэгний зардалд 1,600.0 мянга, урсгал засварын зардалд 2,212.0 мянга, материалын зардалд 4,045.3 мянга, бичиг хэргийн зардалд 841.0 мянга, шуудан холбооны зардалд 870.2 мянга, оюутнуудад буцаан олголт 2,720.0 мянга, шагнал, урамшууллын зардалд 924.5 мянга, бусад зардалд 793.9 мянга, нийт 27,332.9 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 9,641.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд оюутан суралцагчдын хоолонд шаардагдах "Мах, махан бүтээгдэхүүн" 68,904.0 мянга, "Хуурай хүнс" 62,640.0 мянга, "Хүнсний ногоо" 34,800.0 мянга, нийт 166,344.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 багц тендер зарласнаас 2 удаа хүчингүй болж шууд гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Анхтуяа, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06 дугаартай албан бичгээр хугацаа хоцроож ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 2,898,699.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 28,986.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 35,484.3 мянган төгрөгийн 7 тушаал шийдвэр, цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 55,720.9 мянган төгрөгийн орлогын 4, 33,232.1 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээ, тендерийн мэдээлэл тус тус мэдээлээгүй нийт 124,437.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, 6.8.2, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.1.13, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.2.10, 3.2.11 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг нөхөн мэдээлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчил илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад 2023 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд завсрын аудит гүйцэтгэж, нийт 10 горим сорилыг хэрэгжүүлж, асуудлын бүртгэлээр 55,792.8 мянган төгрөгийн 9 алдааг залруулах зөвлөмж өгсөн байна. Нийт 55,792.8 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Залруулсан алдаа:

1. Орлого, үр дүнгийн тайланд цалин, хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг олговол зохих цалингаас 8,175.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
2. Нийгмийн даатгал, татварын тайланд олговол зохих цалингаас 12,227.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.7 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
3. Нийт 2 ажилтны цалин хөлснөөс 648.1 мянган төгрөгийн сахилгын шийтгэлийг суутгахдаа үндсэн цалин хөлсийг бууруулан суутгаж, ХХОАТ, НД-ын тайланд тайлагнаагүй, орлогоор бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", ангилал батламж мэдэгдлийг хангаагүй

4. Арилжааны банкинд харилцах дансны 11.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
5. Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны 11.0 мянган төгрөгийн олз үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй
6. Няравын гаргасан тайлан нягтлан бодогчийн хянасан тайлангаас 439.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС-Бараа материал 12-44, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй
7. Байр болон заалны түрээсийн орлогыг бүртгэхдээ гэрээний дагуу авлага үүсгээгүй, хүлээн авсан 2,759.0 мянган төгрөгөөр орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", УСНББОУС 9-д "14. Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. 15. Ажил гүйлгээнээс үүсэх орлогын дүнг тухайн байгууллага ба түүний хөрөнгө, үйлчилгээг худалдан авагч буюу хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ихэвчлэн тодорхойлдог", ангилал батламж мэдэгдлийг хангаагүй
8. Гэрээ байгуулаагүй, байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус, хууль эрх зүйн актад нийцээгүй 3,180.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 53 дугаар зүйлийн 53.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.1.3, 55.1.7 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 9-д "14. Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. 15. Ажил гүйлгээнээс үүсэх орлогын дүнг тухайн байгууллага ба түүний хөрөнгө, үйлчилгээг худалдан авагч буюу хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ихэвчлэн тодорхойлдог", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй
9. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, 28,340.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|-------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 4,346.4 | 2 | 4,346.4 | 100 |
| Албан шаардлага | 5 | 98,571.2 | 5 | 98,571.2 | 100 |
| Зөвлөмж | 2 | 0.0 | 2 | 0.0 | 100 |
| Нийт дүн | 9 | 102,917.6 | 7 | 102,917.6 | 66.6 |

Өмнөх аудитаар нийт 102,917.6 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлж, 4,346.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 98,571.2 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилтийг хянаж үзэхэд 100%-тай байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,388.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 10,388.0 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулсан алдаа:

1. Ахмадын сангийн 10,388.0 мянган төгрөгийн орлогыг орлого үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн, УСНББОУС 1.27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй

Залруулаагүй алдаа:

Байхгүй

Аудитаар нийт 7,322.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 7,322.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- 5.1.1 Хууль тогтоомжид заагаагүй Эко сургууль хөтөлбөрийн хүрээнд 10 албан хаагчдад 5,795.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, эрх мэдлээ хэтрүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

- 5.1.2 Спидомтерийн заалт давхцуулсан, норм хэтрүүлж шатахууны зардал олгосон, шатахууныг хэрхэн зарцуулсан талаар гүйцэтгэлийг тодорхой бичээгүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан, зөрчлийг засаж сайжруулаагүй 595.7 мянга, 4 ажилтанд томилолтын зардлыг хоног давхардуулан 128.0 мянган төгрөг олгосон, хүнсний материалын үлдэгдэлд биет тооллого хийхэд 802.7 мянган төгрөгийн 11 нэр төрлийн хөрөнгө дутагдсан, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад хяналт тавьж ажиллаагүй нийт 1,526.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийг нөхөх заавар НХМаягт ТМ-4", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 2

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.